



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 01-А/34

Дархан

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргаас олгох “Шагналын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж шинэчлэн баталсугай.


2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-А/16 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЗЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн Д.А/34 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

Аймгийн бүтээн байгуулалт, төр, нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй болон бусад салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, бүс нутаг, аймаг, орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан, тухайн салбартаа онцгой амжилт бүтээл гаргасан ажилтан, албан хаагч, иргэд байгууллага, хамт олон, гадаадын иргэнийг аймгийн Засаг даргын шагнал олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр.Аймгийн Засаг даргын шагнал

Аймгийн Засаг даргын шагналд нэр дэвшигч нь дор дурдсан болзлыг хангасан байна. Үүнд:

2.1.“Хүндэт дэвтэр”-т бичих

Ажил хөдөлмөрийн өндөр амжилт гарган Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, төрийн шагнал, гавьяат цол хүртсэн, аймгийн хүндэт иргэнээр өргөмжлөгдсөн иргэн болон нийгмийн тодорхой нэг салбарын хөгжилд онцгой гавьяа байгуулсан иргэнийг тус тус аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулна.

2.2.“Найрамдлын Дархан” тэмдэг

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд идэвх санаачилга, үр бүтээлтэй 15-аас доошгүй жил ажилласан, Монгол Улсын иргэн, аймгийн гадаад харилцаа болон орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан гадаадын иргэнийг тус тус “Найрамдлын Дархан” тэмдгээр шагнана.

2.3.“Аймгийн Тэргүүний ажилтан” цол тэмдэг

Тухайн онд хамт олноосоо хөдөлмөрийн амжилтаараа шалгарсан 10-аас доошгүй жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэнийг “Аймгийн Тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнана.

2.4 .Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”

Байгууллага, салбарын ой, бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан хөдөлмөрийн амжилт гаргаж, 5-аас доошгүй жил ажилласан иргэнийг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнана.

2.5.“Аймгийн сайн малчин” тэмдэг

Тухайн онд мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг түгээн дэлгэрүүлж залуу үедээ уламжлуулах, малын үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан эрчимжүүлэх, малыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, малчдын нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлэн “Аймгийн Сайн малчин” тэмдгээр шагнана.

2.6. “Аймгийн Тэргүүний тариаланч” тэмдэг

Тухайн жилд тариалангийн үйлдвэрлэлийн технологийг нарийн чанд мөрдөж га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэн аймаг орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг хүн ам хүнсний хэрэгцээг хангахад бодитой хувь нэмэр оруулсан тариаланч, ногоочдыг “Аймгийн Тэргүүний тариаланч” цол, тэмдгээр шагнана.

2.7. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Цагаан Шонхор” шагнал

Цагдаагийн байгууллагад 10-аас дээш жил ажилласан, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад үнэтэй хувь нэмэр оруулсан албан хаагчийг “Цагаан Шонхор” шагналаар шагнана.

(Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаар захирамжаар нэмсэн)

2.8. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Аврагчдын алдар” шагнал

Онцгой байдлын албанд 10-аас дээш жил, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт 3-аас дээш жил ажилласан, орон нутгийн онцгой байдлын албыг бэхжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулж гавьяа байгуулсан, хүний амь нас, эд хөрөнгийг авран хамгаалсан, ажил мэргэжлийн өндөр амжилт гаргасан албан хаагчийг “Аврагчдын алдар” шагналаар шагнах бөгөөд онцгой гавьяа байгуулсан тохиолдолд ажилласан жил харгалзахгүй олгоно.

(Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаар захирамжаар нэмсэн)

Гурав. Аймгийн “Хөдөлмөрийн аварга”

Аймгийн “Хөдөлмөрийн аварга”, “Оны онцлох хүн”, “Тэргүүний баг, аж ахуйн нэгж, байгууллага”-аар шагналд нэр дэвшүүлэх иргэн, хамт олны материалыг холбогдох хэлтсүүд бүрдүүлэн саналын хамт жил бүрийн Билгийн тооллын шинийн нэгэн буюу Цагаан сарын баярын өдрүүд болохоос 14 хонгийн өмнө аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ. Аймгийн “Хөдөлмөрийн аварга”, “Оны онцлох хүн”, Тэргүүний баг, аж ахуйн нэгж, байгууллага”-аар шагнагдах иргэн, хамт олон дор дурдсан болзлыг хангасан байна.

3.1. “Оны онцлох хүн, баг хамт олон”

Улс болон тив, дэлхийд нутаг орны нэрийг мандуулсан, шинжлэх ухааны салбарт шинэ нээлт, бүтээл туурвисан, тэргүүний техник, технологи нутагшуулсан, орон нутгийн бүтээн байгуулалтад томоохон хөрөнгө оруулалт хийсэн, төр захиргаа, хувийн хэвшил, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, спорт, шинжлэх ухааны салбарын ажилтан, албан хаагч, иргэн, баг, хамт олны нэрийг дэвшүүлж материалыг холбогдох хэлтсүүд бүрдүүлэн саналын хамт Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

(Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаартай захирамжаар нэмсэн)

3.2. “Аймгийн тэргүүний сум, баг, аж ахуйн нэгж, байгууллага”

Тэргүүний техник, технологи нэвтрүүлсэн, ажлын байр нэмэгдүүлж, орон нутгийн томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг “Аймгийн тэргүүний сум, баг, аж ахуйн нэгж, байгууллага”-аар доор дурдсан дөрвөн чиглэлээр шалгаруулна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд энэ журамд заасны

дагуу материалыг бүрдүүлэн саналын хамт Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ. Үүнд:

- 1.Аймгийн тэргүүний сум (Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаар захирамжаар нэмсэн)
- 2.Аймгийн тэргүүний баг (2-оос доошгүй)
- 3.Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч хамт олон
- 4.Шинээр ажлын байрууд бий болгосон хамт олон
- 5.Орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулсан хамт олон

3.3.Салбарын хөдөлмөрийн аварга

Иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлсэн, үйлчилгээний соёл стандартыг мөрдөн ажилласан, ёс зүйн хэмжээг зөрчөөгүй иргэн, ажилтныг тухайн оны аймгийн “Салбарын хөдөлмөрийн аварга”-аар доор дурдсан салбар бүрээс шалгаруулна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд энэ журамд заасны дагуу материалыг бүрдүүлэн саналын хамт Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ. Үүнд:

- 1.Аймгийн аварга малчин
- 2.Аймгийн аварга тариаланч
- 3.Аймгийн шилдэг фермер
- 4.Боловсролын салбарын хөдөлмөрийн аварга
- 5.Эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн аварга
- 6.Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аварга
- 7.Дэд бүтцийн салбарын хөдөлмөрийн аварга
- 8.Санхүүгийн салбарын хөдөлмөрийн аварга (төрийн байгууллагуудаас бусад)
- 9.Төрийн байгууллагуудын хөдөлмөрийн аварга
- 10.Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хөдөлмөрийн аварга
- 11.Худалдаа үйлчилгээний байгууллагуудын хөдөлмөрийн аварга
- 12.Соёл, урлагийн салбарын хөдөлмөрийн аварга
- 13.Спорт, аялал жуулчлалын салбарын хөдөлмөрийн аварга

Жич: Энэ журмын 3.1, 3.2, 3.3-т заасан шагналд нэр дэвшүүлж байгаа баг, хамт олон, байгууллага, иргэний материалуудыг холбогдох хэлтсүүд бүрдүүлэн Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ. Материалыг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж, Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

Дөрөв.Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1.Шагналд нэр дэвшигч нь журмын хоёр, гуравдугаар хэсэгт заасан болзлыг хангасан байна.

4.2.Нэр дэвшүүлэгч байгууллага нь энэхүү журмын 2, 3-т заасан болзлыг хангасан иргэнийг дараах хяналтын тооноос хэтрүүлэхгүйгээр шагналд 1 удаа нэр дэвшүүлнэ.

- 4.2.1.20 хүртэл тооны ажилтантай бол -1 хүртэл
- 4.2.2.50 хүртэл тооны ажилтантай бол -2 хүртэл
- 4.2.3.100 хүртэл тооны ажилтантай бол -3 хүртэл
- 4.2.4.150 хүртэл тооны ажилтантай бол -5 хүртэл
- 4.2.5.350 хүртэл тооны ажилтантай бол -10 хүртэл
- 4.2.6.650-аас дээш тооны ажилтантай бол -20 хүртэл

4.3.Аймгийн Засаг даргын шагналыг бусад төрийн дээд болон салбарын шагналтай давхардуулан олгохгүй байх зарчмыг баримтална.

4.4.Шагналд нэр дэвшүүлэх санаачлалыг тухайн нэр дэвшигчийн харьяалагдаж буй үндсэн байгууллага, холбогдох бодлогын хэлтэс гаргаж, материалыг бүрдүүлэн, шалгаруулалт

болох хугацаанаас 14-өөс доошгүй хоногийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

4.5.Шагналд нэр дэвшигч дараах материал бүрдүүлнэ. Үүнд:

4.5.1.Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, сумын Засаг даргын албан бичиг

4.5.2.Шагналд нэр дэвшигч байгууллага, хамт олон, ажилтан, албан хаагч, малчин, тариаланчийн ажил байдлын тодорхойлолт

4.5.3.Шагналд нэр дэвшигчийн танилцуулга-анкет

4.5.4.Хамт олны хурлын тэмдэглэл;

4.5.5.Онцгой амжилт бүтээл, гавьяа зүтгэл гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, тодорхойлолт

4.6.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын удирдлага нэр дэвшигчийн тодорхойлолт, анкетыг саналын хамт аймгийн Засаг даргад ирүүлнэ. Ажлын үр дүнгийн тодорхойлолтод шагнуулах үндэслэл, ажлын амжилтаа үнэн зөв, товч тодорхой тусгасан байх бөгөөд урьд нь авч байсан шагналд дахин нэр дэвшүүлэхгүй байх болон өмнө нь авсан шагналаас бууруулахгүй байх зарчим баримтална.

4.7.Аймгийн Засаг даргын шагналд тодорхойлох шагнал хоорондын хугацаа 3-5-аас дээш жил байна. Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд энэ журам хамаарахгүй.

4.8.Аймгийн Засаг даргын шагналын холбогдох материалыг жил бүрийн Үндэсний их баяр наадам, Билгийн улирлын шинийн нэгэн буюу Цагаан сар, Их Эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын ойн өдөр, салбарын ойн өдрүүдийг тохиолдуулан тэмдэглэлт өдрүүд болохоос 14 хоногийн өмнө аймгийн Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч хүлээн авна.

4.9.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн энэхүү журмын 4.5-д заагдсан болзлын шаардлага хангасан шагналын материалыг нягтлан үзэж хавсралтаар батлагдсан маягыг боловсруулан нэгтгэж Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргаар хянуулан аймгийн Засаг даргад уламжилна.

4.10.Шагналын бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагналын олгохгүй ба дараагийн 3 жилд шагналд нэр дэвшүүлэхгүй.

4.11.Шагналыг давхардуулан олгохгүй.

Тав.Шагнах асуудлыг шийдвэрлэх, гардуулах

5.1.Шагналд нэр дэвшигчийн материалыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хүлээн авч, холбогдох журмын дагуу хянан боловсруулж тухайн байгууллагын харьяалах хэлтсээс саналыг нь авч, аймгийн Засаг даргад уламжлан ажлын 7-14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.2.Олон албан хаагч, ажиллагсадтай салбарын нэгж байгууллагуудын шагналд нэр дэвшүүлсэн хүмүүсийн материалыг тухай салбарын удирдлагын баталгаажуулсан албан бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

5.3.Бүрдэл дутуу ирүүлсэн материалыг хүлээн авахгүй бөгөөд үүнээс үүсэх үр дагаврыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцахгүй.

5.4.Шагналыг аймгийн Засаг дарга болон түүний зөвшөөрснөөр аймгийн Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар ёслол хүндэтгэлтэйгээр гардуулна.

Зургаа.Шагналын дагалдах мөнгөн шагнал, баталгаа

6.1.Хүндэт дэвтэрт бичигдсэн иргэнд баталгаа болгон гэрчилгээ олгох ба 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.2.“Найрамдлын Дархан” тэмдэг, үнэмлэх, мөнгөн шагнал 120,000 (зуун хорин мянга) төгрөг олгоно.

6.3.“Аймгийн Тэргүүний ажилтан” тэмдэг, үнэмлэх, мөнгөн шагнал 80,000 (наян мянга) төгрөг олгоно.

6.4.Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж 50,000 (тавин мянга) төгрөг олгоно.

6.5.Аймгийн Засаг даргын нэрэмжит “Цагаан Шонхор”-оор шагнагдахад өргөмжлөл, мөнгөн шагнал 3,000,000 (гурван сая) хүртэлх төгрөгийг гаргасан амжилтаас шалтгаалж олгоно. (Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаар захирамжаар нэмсэн)

6.6.Аймгийн Засаг даргын нэрэмжит “Аврагчдын алдар”-аар шагнагдахад өргөмжлөл, мөнгөн шагнал 3,000,000 (гурван сая) хүртэлх төгрөгийг гаргасан амжилтаас шалтгаалж олгоно. (Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаар захирамжаар нэмсэн)

6.7.“Аймгийн Аварга малчин” цол тэмдэг, тууз, цом, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.8.“Аймгийн Аварга тариаланч” цол тэмдэг, тууз, цом, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.9.“Аймгийн Шилдэг фермер” цол тэмдэг, тууз, цом, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.10.“Оны онцлох” хүнээр шалгарахад үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 1,000,000 (нэг сая) төгрөг олгоно.

6.11.“Оны онцлох хамт олон”-оор шалгарахад үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 3,000,000 (гурван сая) төгрөг олгоно.

(Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаар захирамжаар нэмсэн)

6.12.“Салбарын хөдөлмөрийн аварга”-аар шалгарахад өргөмжлөл, мөнгөн шагнал 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.13.“Тэргүүний сум”-аар шалгарсан сумд үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 1,000,000 (нэг сая) төгрөг олгоно. (Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01-А/34 дугаар захирамжаар нэмсэн)

6.14.“Тэргүүний баг”-аар шалгарсан баг тус бүрд нь үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 1,000,000 (нэг сая) төгрөг олгоно.

6.15.“Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч хамт олон”-д үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.16.“Шинээр ажлын байрууд бий болгосон хамт олон”-д үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.17.“Орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад хувь оруулсан хамт олон”-д үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно.

6.18.Аймгийн Засаг даргын шагналаар шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгогдохгүй.

6.19.6.2, 6.3, 6.4-д заасан шагналуудын дагалдах мөнгөн шагналыг тодорхойлолт гаргасан тухайн байгууллагын холбогдох зардлаас санхүүжүүлнэ.

Долоо.Шагналын мэдээллийн сан ба шагнал нөхөн олгох

7.1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын шагнагдсан ажилтнуудын мэдээллийн сантай байх, мэдээллийн санг шагналын төрөл, олгосон хугацаа, оноор төрөлжүүлсэн байна.

7.2.Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцна.

7.3.Аймгийн сумд болон төрийн, төрийн бус байгууллагууд нь ажилтны шагналын бүртгэл, мэдээллийн сантай байх ба шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шинээр шагнагдах хүмүүсийн шагналын судалгааг гаргаж дотоод хяналт тавина.

7.4.Аймгийн Засаг даргын шагналыг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөж олгож болно.

7.4.1.Нөхөн олгоход дараах материал бүрдүүлнэ.

А)Дахин олгохыг хүссэн өргөдөл

Б)Шагналын баталгаа үнэмлэх

В)Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн дансанд 10.000

(арван мянга) төгрөг тушаасан баримт

Найм.Хариуцлага

8.1.Шагналтай холбоотой бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлж ирүүлсэн, нэгтгэсэн болон хянасан албан тушаалтныг шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж хариуцлага тооцно.